



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:92-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

2019.10.14 № 1626
танай _____-ны № _____-т

Аудитын дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9 дэх заалтын дагуу Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 10.хуудастай.



Д.ЗАНДАНБАТ

070199

Агуулга

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
НЭГ. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА, ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙГ ХАНГАЖ БУЙ ЭСЭХ.....	2
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ	4
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ	5
ДӨРӨВ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, КОНЦЕССЫН ТАЛААР	5
ТАВ. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН.....	7
ЗУРГАА. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ.....	7
ДОЛОО. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА	8
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:.....	9
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ	10

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9-д “Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөлд хийсэн аудитын . . . дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулж танилцуулах” гэж заасны дагуу Үндэсний аудитын газар дүгнэлт гаргалаа.

Энэхүү дүгнэлтийг гаргахдаа Төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Нийгмийн даатгалын сангийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай, Ирээдүйн өв сангийн тухай зэрэг хуулиудын холбогдох зүйл, заалт, УИХ-ын 2019 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэргийг шалгуур үзүүлэлт болгов. Тухайлбал,

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төсвийн тусгай шаардлага, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан Төсвийн хүрээний мэдэгдлийг хангасан эсэх;
2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээтэй уялдсан эсэх;
3. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт нь төсөвлөлтийн шаардлагад нийцсэн эсэхийг хяналаа.

Засгийн газраас 2019 онд баримталсан эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “**Цахим, ул тод, үр ашигтай**” төсвийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2020 оны төсвийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 11,797.8 тэрбум төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид ДНБ гэх/-ий 29.0 хувь, нийт зарлагын дээд хэмжээг 13,872.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.1 хувь, тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,074.7 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий -5.1 хувьтай тэнцэхээр төсвийн төсөлд тусгасан байна.

НЭГ. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА, ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙГ ХАНГАЖ БҮЙ ЭСЭХ

Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, УИХ-аас баталсан 2020 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж төлөвлөсөн эсэхэд дараах дүгнэлтийг өгч байна.

Хүснэгт №1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал:

№	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага	Төсвийн төсөлд тусгагдсан байдал	Хангагдсан эсэх
1	6 дугаар зүйл: 6.1.1. “нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх”	2020 онд нүүрс болон зэсийн баяжмалаас төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын 3 хувиас давахаар байгаа тул Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцож нэг тонн цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 6,222.2 ам.доллар, нэг тонн нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 75.9 ам.доллар байхаар тооцсон байна.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу 2020 онд зэсийн баяжмал болон нүүрснээс нийт 2,615.0 тэрбум төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцсон нь нэгдсэн төсвийн орлогын 23.6 хувийг эзэлж байна. Шаардлага: Хангагдсан.
2	6 дугаар зүйл: 6.1.2. “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэсэн заалтад 19 дүгээр зүйлийн 19.9-д “6.1.2-т ... 2020 онд тухайн жилийн ДНБ-ий 5.1 хувиас илүүгүй байх” гэсэн өөрчлөлт орсон.	2020 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,074.7 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн нь Засгийн газраас тооцоолсон ДНБ (40,683.1 тэрбум төгрөг)-ийн -5.1 хувьтай тэнцүү байна.	2020 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг -5.1 байхаар тооцсон байна. Шаардлага: Хангагдсан.
3	6 дугаар зүйл: 6.1.3. “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээх хэтрэхгүй байх”	2020 оны нэгдсэн төсвийн төслийн нийт зарлагын өсөлт 19.7 хувь байхаар тооцжээ.	2008-2019 оны дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 19.8 хувь байна. Шаардлага: Хангагдсан.
4	6 дугаар зүйл: 6.1.4. “Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх” гэсэн заалтад 19 дүгээр зүйлийн 19.3-т “Энэ хуулийн 6.1.4-т ... 2020 онд ДНБ-ий 70 хувиас хэтрэхгүй байна” гэсэн өөрчлөлт орсон.	Нэгдсэн төсвийн төсөлд Засгийн газрын өр өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий 49.9 хувьд хүрэх төлөвтэй байна.	Нэгдсэн төсвийн төсөлд Засгийн газрын өр өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий 49.9 хувьд хүрэх төлөвтэй байна. Шаардлага: Хангагдсан.

Эх сурвалж: Төсвийн хүрээний мэдээгдэл, Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөл

Дүгнэлт:

- Нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан тусгай шаардлагуудыг хангаж байна.

Хүснэгт №2. Төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлсэн байдал:

Д/Д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл /2019.05.30-нд батлагдсан/	2019.09.30-ны өргөн мэдүүлсэн Төсвийн төсөл	Өөрчлөлт
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.0	6.0	-
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.0	-
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	11,122.6	11,797.8	675.2
	ДНБ-д эзлэх хувь	27.3	29.0	1.7
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	13,197.4	13,872.6	675.2
	ДНБ-д эзлэх хувь	32.4	34.1	1.7
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,608.3	2,283.5	675.2
	ДНБ-д эзлэх хувь	4.0	5.6	1.6
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	(2,074.7)	(2,074.7)	-
	ДНБ-д эзлэх хувь	(5.1)	(5.1)	-
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	3,491.4	3,678.9	87.5
	ДНБ-д эзлэх хувь	8.6	9.0	0.4
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	22,089.1	22,089.1	-
	ДНБ-д эзлэх хувь	54.3	54.3	-
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	750.2	756.6	6.4
	ДНБ-д эзлэх хувь	1.8	1.9	0.1

Эх сурвалж: Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, 2019.05.30-нд батлагдсан 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөлөл

Дүгнэлт:

- УИХ-аас 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан нэгдсэн төсвийн нийт орлогыг 675.2 тэрбум, хөрөнгийн зардлыг 187.5 тэрбум, урсгал зардлыг 487.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр хуулийн төсөл санаачилсан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн удирдлагын зарчим, төсвийн төсөл боловсруулахад баримтлах шаардлагад нийцэхгүй байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 12,900.0 тэрбум, тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 11,797.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсний 90.3 хувийг татварын орлогоор, 9.7 хувийг татварын бус орлогоор бүрдүүлэхээр тооцжээ. Үүнээс татварын орлогыг 2019 оны батлагдсан төсвөөс 2,070.4 тэрбум төгрөгөөр буюу 24.1 хувиар, татварын бус орлогыг 50.9 тэрбум төгрөгөөр буюу 4.7 хувиар нэмэгдүүлсэн байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөллийг 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 1,546.9 тэрбум төгрөгөөр буюу 15.1 хувиар өсөхөөр тооцоолсон байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу нэгдсэн төсвийн орлогын гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүн зэс, нүүрс байхаар тооцогдож байна.

Дүгнэлт:

- Дэлхийн эдийн засгийн өсөлт саарах, мэргэжлийн судалгааны байгууллагуудын төсөөллөөр зэсийн үнэ төлөвлөсөн хэмжээнээс буурах төлөвтэй, нүүрсний борлуулалтын тоо хэмжээг 2018 оны гүйцэтгэлээс 15.7 хувиар өндөр буюу 42.0 сая тонноор тооцсон зэргээс үзвэл төсвийн орлогын төлөвлөгөө биелэх эсэх, улмаар зарлагын эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байна.
- Гааль, татварын шинэчлэлээр ирэх оны төсвийн орлого нэмэгдэх нөлөөлөл багатай, дунд, урт хугацаанд өгөөжөө өгөхөөр байгаа ба татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оны батлагдсан төсвөөс 2,070.4 тэрбум төгрөгөөр буюу 24.1 хувиар нэмэгдүүлэн тооцоолсон нь эрсдэлтэй байна.
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг бодитой төлөвлөх, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьцааны ногдол ашгийг бүрэн ногдуулснаар төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх боломж байна.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ

Нэгдсэн төсвийн 2020 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 13,872.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснийг 2019 оны батлагдсан төсөвтэй харьцуулбал 2,283.5 тэрбум төгрөгөөр буюу 19.7 хувиар нэмэгдүүлэн тооцжээ.

Зарлагын өсөлтийн бүтцийг авч үзвэл урсгал зарлагыг 1,721.0 тэрбум, хөрөнгийн зардлыг 435.2 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 127.3 тэрбум төгрөгөөр тус тус өсгөхөөр төлөвлөсөн байна.

Урсгал зардлын 26.4 хувийг цалин хөлс, 21.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 9.6 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, 42.5 хувийг тэтгэвэр тэтгэмжийн зардал эзэлж байна.

Дүгнэлт:

- Төсөвт байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой зарим үр ашиггүй урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, өмнөх түвшнээс нэмэгдүүлэхгүй байх замаар төсвийн алдагдлыг бууруулах боломжтой байна.
- Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг сүүлийн 5 жилээр судалж үзэхэд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлын төсөв жил бүр 15.0-21.4 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь төрийн албан хаагчийн орон тоо, цалингийн сангийн нэгдсэн цахим системийг бий болгож, ашиглах шаардлагатайг харуулж байна.

ДӨРӨВ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, КОНЦЕССЫН ТАЛААР

Төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,639.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1102 төсөл, арга хэмжээнд 1,658.7 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс нийгмийн салбарт 762.5 тэрбум, дэд бүтцийн салбарт 537.0 тэрбум, бусад салбарт 359.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон байна. Үүнээс 626 нь шинээр, 476 нь өмнөх оноос шилжин хэрэгжих, мөн 325 нь барилга байгууламж, 80 нь тоног төхөөрөмж, 213 нь их засвар, 8 нь ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээ байна.

Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8-д заасныг үндэслэн Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор тодотгон баталж, нийт 35 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 1,005.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай гэж төлөвлөснийг төсвийн төсөлд тусгасан байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан хөрөнгө оруулалтын шинж чанартай 42 төсөл, арга хэмжээнд 1,376.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, 786.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсвийн төсөлд тусгасан боловч зарим томоохон төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн шаардлагыг хангаагүй нийт 368.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 91.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх 34 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгасан нь хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих төсөл, арга хэмжээнд хамаарах 100.0-800.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий багийн төвийн барилга, хорооллын гудамж талбай, явган хүний замын гэрэлтүүлэг зэрэг нийт 3.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 16 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Түүнчлэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудалд хамаарахгүй, төслийн хүрээнд хийх ажил нь тодорхойгүй, урсгал зардлын шинжтэй 6.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээнд 4.2 тэрбум төгрөг олгохоор тусгасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах 20 барилга, байгууламжийн өртөг баталгаажсан төсөвт өртгөөс 28.2 тэрбум төгрөгийн зөрүүтэй тусгагдсан нь төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, дутуу орхигдох зэрэг эрсдэл үүсэж болзошгүй тул төсөвт өртгийн дүнг нягталж, баталгаажсан өртгөөр тусгах эсвэл бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дахин зураг, төсөв хийлгэх шаардлагатай.

Төсвийн төсөлд концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 1,073.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төслийн эргэн төлөлтөд 323.6 тэрбум төгрөгийг олгохоор төлөвлөсөн байна.

Концессын гэрээний үнийг гадаад валютаар төлөхөөр байгуулснаас шалтгаалан 2020 онд эргэн төлөлт хийгдэх 5 төсөл, арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртөг валютын ханшийн зөрүүгээр 81.1 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна.

Үндэсний хөгжлийн газар концессын төслийн хэрэгжилттэй уялдуулан гэрээний эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулсны дараа төсвөөс олгох санхүүжилтийг төлөвлөх шаардлагатай байна.

Дүгнэлт:

- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, хэрэгцээ шаардлага тодорхойгүй, төсөвт өртөг зөрүүтэй зарим төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгасан нь хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний өртөгт хязгаар тогтоох, тавигдах шалгуурыг илүү тодорхой болгох шаардлагатай байна.

ТАВ. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Орон нутгийн төсвийн суурь орлогыг 2020 онд 1,348.9 тэрбум, суурь зарлагыг 857.7 тэрбум төгрөгөөр төлөвлөжээ.

Бүс нутгийн хөгжлийг дэмжих, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг өмнөх оноос 120.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 624.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

Улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох орлогын шилжүүлгийг өмнөх оноос 30.1 хувиар нэмэгдүүлж, 188.4 тэрбум төгрөгт хүргэж төлөвлөжээ.

Дүгнэлт:

- Төсвийн тухай хуульд заасан нөхцөл шаардлага үүсээгүй байхад орон нутгийн зарим төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн тодотголыг өргөн мэдүүлж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж байгааг Улсын Их Хурлын анхааралд толилуулж байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд хяналтыг сайжруулах шаардлагатай байгаа нь жил бүр Үндэсний аудитын газраас хийсэн аудитын дүгнэлтээс харагдаж байна.

ЗУРГАА. НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,074.7 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн байна. Үүнд:

1. Нэгдсэн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор 2020 онд Засгийн газрын гадаад төслийн болон хөтөлбөрийн зээлээс 2,563.7 тэрбум, Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдлээс 478.8 тэрбум, өмч хувьчлалын орлогоос 0.7 тэрбум, нийт 3,043.2 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөжээ. Үүнийг бүтцээр нь авч үзвэл:
 - 1.1 УИХ-аас соёрхон баталсан гэрээний дагуу гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас төсвийн 16 ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын шугамаар хэрэгжүүлж буй 115 төсөлд нийт 1,296.3 тэрбум төгрөгийн төслийн зээл,
 - 1.2 Олон улсын валютын сангийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Япон Улсын Жайка байгууллагаас нийт 1,267.4 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл авахаар тус тус тооцсон байна.
 - 1.3 Төсвийн тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдлээс 478.8 тэрбум төгрөгийг төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг нөхөхөд зарцуулахаар тусгажээ.
2. Нэгдсэн төсвийн алдагдлыг нөхөхөд зориулан дээрх эх үүсвэрээс Засгийн газрын дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 263.0 тэрбум, гадаад төслийн зээлийн эргэн төлөлтөд 705.5 тэрбум, нийт 968.5 тэрбум төгрөгийг зарцуулж, үлдэх 2,074.7 тэрбум төгрөгөөр Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Дүгнэлт:

- Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлогыг бодитой төлөвлөж, зардлыг бууруулснаар нэгдсэн төсвийн алдагдлыг багасгах боломж байгааг анхаарах шаардлагатай байна.

ДОЛОО. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА

Төсвийн төсөлд Засгийн газрын өрийг нэрлэсэн дүнгээр 26,280.6 тэрбум, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлснээр 20,301.7 тэрбум төгрөг буюу ДНБ-д эзлэх хэмжээг 49.9 хувь байхаар тусгасан байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэлд гадаад өр 23,289.0 тэрбум төгрөг буюу 88.6 хувийг, Засгийн газрын өрийн баталгаа 1,088.5 тэрбум төгрөг буюу 4.1 хувийг, дотоод өр 1,903.1 тэрбум төгрөг буюу 7.3 хувийг тус тус эзлэхээр байна.

Засгийн газрын өрийн багцын 92.7 хувийг гадаад валютаар илэрхийлсэн өр эзэлж байгаа нь гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж төгрөгөөр илэрхийлсэн Засгийн газрын өр өсөхөд нөлөөлж болзошгүй байна.

Дүгнэлт:

- Төсвийн төсөлд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн хэмжээ нь Улсын Их Хурлаас 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан хязгаарыг хангаж байна.
- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” баримт бичигт “... гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийг өөрчлөн зохицуулж, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 58.6 хувиас хэтрүүлэхгүй байх” гэсэн өрийн шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн төслийг боловсруулахдаа жил бүр макро түвшний судалгаа, гадаад, дотоод хүчин зүйлсийн үндэслэлийг бодитой тооцдоггүйгээс УИХ-аар батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахаар хууль санаачилж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг тууштай хэрэгжүүлэхгүй байна.
- Үндэсний аудитын газраас нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Улсын Их Хурлын анхааралд толилуулсан удаа дараа давтагдаж буй Төсвийн тогтвортой байдал хангагдахгүй байгаа зөрчлийг арилгах, цаашид жил бүрийн төсвийн төслийг боловсруулах, батлахдаа баримтлах шаардлагатай байна.
- Дэлхийн эдийн засгийн өсөлт саарах, мэргэжлийн судалгааны байгууллагуудын төсөөллөөр зэсийн үнэ төлөвлөсөн хэмжээнээс буурах төлөвтэй, нүүрсний борлуулалтын тоо хэмжээг 2018 оны гүйцэтгэлээс 15.7 хувиар өндөр буюу 42.0 сая тонноор тооцсон зэргээс үзвэл төсвийн орлогын төлөвлөгөө биелэх эсэх, улмаар зарлагын эх үүсвэр дутагдах эрсдэл байна.
- Гааль, татварын шинэчлэл дунд, урт хугацаанд өгөөжөө өгөхөөр байгаа нь ирэх оны төсвийн орлого нэмэгдэх магадлал багатай, татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оны батлагдсан төсвөөс 2,070.4 тэрбум төгрөгөөр буюу 24.1 хувиар нэмэгдүүлэн тооцоолсон нь эрсдэлтэй байна.
- Нэгдсэн төсвийн зарлага өмнөх оны батлагдсан төсвөөс 2,283.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа тул эрсдэлд суурилсан хяналтын бодлого баримталж, дотоод хяналт, дотоод аудитын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.
- Төсвийн төсөлд тусгагдсан зарим төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, хэрэгцээ шаардлага тодорхойлогдоогүй, төсөвт өртөг зөрүүтэй байгаагаас хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний өртөгт хязгаар тогтоох, тавигдах шалгуурыг илүү тодорхой болгох шаардлагатай байна.
- Эдийн засгийн өсөлттэй өнөө үед төсвийн төслийг боловсруулахдаа зардлыг бууруулж, инфляцийг барих бодлого баримтлах шаардлагатай байна.
- Төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай байгаа нь Засгийн газрын өрийг нэмэгдүүлэх, түүнчлэн валютын нөөцийн хомсдол үргэлжлэх эрсдэлтэй байна.
- Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалт, экспортыг дэмжих, валютын нөөцийг нэмэгдүүлэх талаар үр өгөөж бий болохуйц бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Ази, номхон далайн бүсийн байгууллагын өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээнээс шалтгаалан 2019 оны 10 дугаар сард болох тус байгууллагын хуралдаанаар Монгол Улс хяналт/саарал жагсаалт/-д орох өндөр эрсдэлтэй байгааг тооцон, жагсаалтад орсон тохиолдолд улсын төсвийн орлого буурах, зээлийн хүүгийн зардал өсөж дунд, урт хугацаанд төсөвт сөрөг нөлөөлөл бий болох эрсдэл үүсэж болзошгүйг зайлшгүй анхаарах шаардлагатай байна.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/74

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.9, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн төсөлд өгөх санал дүгнэлт боловсруулах ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, ажил гүйцэтгэх хуваарийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн төсөлд санал өгөх ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, санал дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторт 2019 оны 10 дугаар сарын 14-ний дотор танилцуулж, хуульд заасан цаглабарт хугацаанд УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч /С.Оюунбилэг/-д даалгасугай.



Д.ЗАНДАНБАТ

Монгол Улсын Ерөнхий аудиторовын
2019 оны 09 сарын 20 өдрийн 074 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ
САНАЛ, ДҮГНЭЛТ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Ажлын хэсгийн ахлагч: С.Оюунбилэг (Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор)

Гишүүд: Ц.Наранчимэг (Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор)

Б.Бундхорол (Стратеги удирдлагын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор)

Б.Мөнх-Очир (Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор)

С.Энхбаатар (Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор)

Н.Анхбаяр (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Г.Гүнжидмаа (САГ-ын аудитын менежер)

С.Оюунгэрэл (САГ-ын аудитын менежер)

Я.Самбууням (САГ-ын аудитын менежер)

Л.Эрдэнэчулуун (ГАГ-ын аудитын менежер)

Б.Саруул (ГАГ-ын аудитын менежер)

Нарийн бичгийн дарга: Л.Хонгорзул (САГ-ын ахлах аудитор)